



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГАЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

Улаанбаатар хот
2015 он

Агуулга

<u>Аудитын тайлан</u> <u>бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар	2
<i>Нийцлийн</i> <i>аудитын газар</i>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
Газрын дарга: Б. Алтанзул	Үндсэн мэдээлэл	4
Аудитын менежер: З.Ариунзаяа	Бүлэг-1: Газар тариалангийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт.....	5-9
Ахлах шинжээч: Я.Наранцэцэг	1.1: Төрөөс баримтлах бодлогын хүрээнд зарим холбогдох баримтуудыг боловсруулан баталж гаргасан боловч хэрэгжилт хангалтгүй байна	5
Ахлах шинжээч: Д.Ичин	1.2: Тариаланг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөг бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулж боловсруулсан боловч төлөвлөгөөнд тусгагдсан зарим зорилтын хэрэгжилт хангалтгүй байна	7
Аудитор: Д.Дорждулам	1.3: Тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээхтэй холбогдсон журмыг боловсруулаагүй тодорхой ажил зохион байгуулаагүй байна.....	8
Шинжээч: Д. Эрдэнэцогт Ш.Наранбаатар	Бүлэг-2: Газар тариалангийн талаар төрөөс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа.....	10-17
2015 оны 4 дүгээр сар	2.1: Хэрэгжүүлж буй төслүүд, хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтдоо хүрээгүй байна	10
Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү: <u>www.audit.mn</u>	2.2: Хөнгөлөлттэй олгосон техник, тоног төхөөрөмжийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна	13
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729 дугаарын утас,260949 дугаарын факсаар харилцана уу.	2.3: Тариалангийн салбарт улсын төсвийн болон гадаадын зээл тусламжаар техник төхөөрөмж нийлүүсэнээр хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулах нөхцлийг бүрдүүлжээ	16
Хаяг: Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3 Улаанбаатар-15160 Монгол Улс	Бүлэг-3: Тариалангийн газар ашиглалтын байдал, тариалангийн газрыг нөхөн сэргээх, үйл ажиллагаа.....	18-19
	3.1: Газар тариалангийн газрын бүртгэл мэдээлэлийн сан бий болгохтой холбоотой ажлын явц эхлэл төдий байна	18
	3.2: Тариалангийн газарт нөхөн сэргээлт хийх ажил хийгдээгүй байна	18
	Бүлэг-4: Тариалангийн тухай хууль, тогтоомж, журмын хэрэгжилтэнд тавих дотоод хяналт	20-21
	4-1: Тариалангийн тухай хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй байна.....	20
	Дүгнэлт.....	22
	Зөвлөмж.....	23
	МУ-ын Ерөнхий аудиторовын тушаал.....	24
	Хавсралт.....	25-26

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТТХ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
ГТБХЗГ	Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези зураг зүйн газар
МААБХЗГ	Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СБТГ	Стратеги бодлого, төлөвлөлтийн газар
СС	Сангийн сайд
ТҮДТ	Техник үйлчилгээний дундын төв
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
УИХ	Улсын Их Хурал
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ХААЖДҮГ	Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 3 дугаар тогтоол, Үндэсний аудитын газраас Ерөнхий аудиторт 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Тариалангийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн, төрөөс газар тариалангийн салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж байгаа эсэхэд аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Энэхүү зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Газар тариалангийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт зорилтод түвшинд хүрсэн эсэх;
- Газар тариалангийн талаар төрөөс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа төлөвлөсөн зорилго, зорилтодоо хүрч үр өгөөжөө өгч байгаа эсэх;
- Тариалангийн газар ашиглалтын байдал, газрын нөхөн сэргээх ажиллагаа үр дүнтэй явагдаж байгаа эсэх;
- Тариалангийн тухай хууль тогтоомж болон энэ хуультай нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд дотоод хяналт тавигдаж байгаа байдал.

Аудитын хамрах хүрээ

Аудитыг батлагдсан төлөвлөгөөний дагуу ҮХААЯ, түүний харьяа байгууллагууд, ТЭДС, газар тариалангийн салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжиж буй аж ахуй нэгж байгууллагыг хамруулан тэдгээрийн ажлын тайлан, статистик мэдээ, судалгаа болон холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, аудитын дээд байгууллагын олон улсын стандарт /4000/ түүнийг хэрэгжүүлэх журам, аргачилсан зөвлөмж арга зүйг ашиглаж, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

1. Төрийн аудитын тухай хууль;
2. Төсвийн тухай хууль;
3. Тариалангийн тухай хууль;
4. Таримал ургамлын үр сортын тухай хууль;
5. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль;
6. Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд;
7. Газрын нэгдмэл сангийн 2013 оны улсын нэгдсэн тайлан.

Аудитын тайлангийн төсөлд санал авахаар ХХАА-н сайдад хүргүүлсэн боловч хуулийн хугацаанд тайлангийн төсөлд санал ирүүлээгүй болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Тариалангийн тухай хууль 2004 онд батлагдсанаар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, тариалангийн газрыг зүй зохистой ашиглах, үржил шимийг нь хамгаалахтай холбогдсон төр, иргэн, ААНБ-уудын хооронд үүсэх харилцааг зохицуулах хууль эрх зүйн шинэ тогтолцоо бүрэлдсэн байна.

ҮХААЯ нь Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод 12, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 5, Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогод 14, тухайн жилийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 20 зорилтууд дэвшүүлж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллажээ.

Хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилтын хүрээнд, газар тариалангийн үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, бүтээгдэхүүний төрөл зүйлийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа эдгээр арга хэмжээний дүнд усалгаатай тариалангийн талбайг 1076 га-аар нэмэгдүүлэн, 33.9 мянган тоннын багтаамж бүхий төмс хүнсний ногооны зоорь ашиглалтанд оруулжээ.

Чацаргана үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн хугацаанд улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар 10.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл дэмжлэгийг олгосноор тариалсан талбай 3.34 дахин, ургацын хэмжээ 3.38 дахин нэмэгдсэн байна.

Улсын төсвийн болон гадаадын зээл тусламжийн хүрээнд газар тариалангийн салбарт 60.6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжиж 42.8 тэрбум төгрөгийн төхөөрөмжийг тариаланчдад зээлээр олгосон ба тариалалт, арчилгаа, тордолгоо, ургац хураалтын технологи хугацаа 4-14 хоногоор буурч, хүнсний ногооны тариалалтанд гар ажиллагааг хөнгөвчлөх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх нөхцөл бүрджээ.

Гэвч тариалангийн зориулалттай газрын ашиглалтыг дээшлүүлэх, үржил шимийг сайжруулах, талбайг хөрсний эвдрэлээс хамгаалах, нөхөн сэргээх, өмчлүүлэх замаар эдийн засгийн эргэлтэнд оруулах, нэгж талбаруудыг бүртгэлжүүлэх, мэдээллийн сан бий болгох, ажлууд эхлэл төдий хийгдсэн байна.

2010-2014 онд улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зээлд тариаланчдыг хамруулах чиглэлээр Засгийн газрын зүгээс ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулсан төдийгүй 2011-2013 онд 1034.5 мянган тонн улаанбуудай тариалсан тариаланчдад 78.5 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон бөгөөд 2014 онд 35.3 тэрбум төгрөгийг олгохоор төлөвлөжээ.

БҮЛЭГ 1. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

1.1 Төрөөс баримтлах бодлогын хүрээнд зарим холбогдох баримтуудыг боловсруулан батлаж гаргасан боловч хэрэгжилт хангалтгүй байна

Тариалангийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд боловсруулсан баримт бичгүүдийн хэрэгжилтийн байдлыг авч үзвэл:

/Хүснэгт №1/

Тариалангийн талаарх бодлогын баримт бичгүүд	Баримт бичигт тусгагдсан зорилт	Хэрэгжсэн болон хэрэгжих шатанд байгаа зорилтууд	Бүрэн хэрэгжээгүй зорилтууд	Хэрэгжээгүй зорилтууд
Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого	12	7	3	2
Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого	14	7	7	
ЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр	5	3		2
Нийт дүн	31	17	10	4

Төрөөс газар тариалангийн салбарт баримтлах бодлогын хүрээнд 31 зорилт дэвшүүлснээс 17 зорилт буюу 54.8 хувь нь хэрэгжсэн болон хэрэгжих шатандаа, 10 зорилт буюу 32.2 хувь нь бүрэн хэрэгжээгүй, 4 зорилт буюу 12.9 хувь хэрэгжээгүй байна.

Тариалангийн талаар төрөөс баримтлах дараах зорилтууд хангалттай хэрэгжсэн байна. Тухайлбал:

- 2013 онд Улсын төсвийн 4.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар төрийн болон орон нутгийн өмчийн 10 услалтын системийг шинээр барьж сэргээн засварласнаар усалгаатай тариалангийн талбайг 1076 га-гаар нэмэгдүүлсэн.
- Таримал ургамлын үр үржүүлэг, таримлын сэлгээ, шинэ сортуудыг сорих нутагшуулах сорт сорилтын төвүүдийн үйл ажиллагааг сэргээх ТЭЗҮ боловсруулах зорилгоор зөвлөх үйлчилгээний тендер зарлаж 198.0 сая, алслагдсан бүсэд газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх ТЭЗҮ-ийг боловсруулахад 98.0 сая нийт 296.0 сая төгрөгийн гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн.
- Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн техник, технологи, эдийн засаг, менежментийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор 2013 онд "Фарм шоу-2013" техник технологийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 14 орны 90 орчим үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн сурталчлагдаж 3.0 тэрбум гаруй төгрөгийн гэрээ хэлцэл, борлуулалт хийгдсэн байна.

Тариалангийн талаар төрөөс баримтлах бодлогуудын хэрэгжээгүй байгаа зорилт тус бүрийг авч үзвэл:

I/. Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод газар тариалангийн чиглэлээр дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт хангалтгүй байгаа нь баримт бичгийг боловсруулах явцад судалгаа шинжилгээ хийгдээгүй, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тусгаж өгөөгүйтэй холбоотой байна.

Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд хэрэгжээгүй болон бүрэн хэрэгжээгүй зорилтууд ба шалтгааныг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт №2/

Д.д	Хэрэгжээгүй зорилтууд	Шалтгаан
1	Газар тариалангийн болон эрчимжсэн фермерийн аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа газрыг өмчлүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Газрын тухай болон газар өмчлүүлэх тухай хуулиудад иргэнд газар тариалангийн зориулалтаар газар өмчлүүлэх эрх зүйн орчин бий болгосон ч тодорхой ажил хийгдээгүй байна.
2	Хөрсний үржил шимийг хамгаалах талаарх эрх зүйн орчин, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох	Хөрсний үржил шимийг хамгаалах, хяналтын тогтолцооны талаар хуульд тусгагдсан боловч шаардлагатай журмыг шинээр боловсруулж батлаагүй, зарим дүрэм журамд хуульд нийцүүлэн нэмэлт өөрчлөлтүүд хийгээгүй байна.

Бүрэн хэрэгжээгүй зорилтуудын талаар:

/Хүснэгт №3/

Д.д	Бүрэн хэрэгжээгүй зорилтууд	Шалтгаан
1	Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлэх зорилтын хүрээнд	ҮХААЯ 2013 онд ТЭДС-аар дамжуулан үр ариутгалын бодис 7.8 мянган литр, алмазис 798.0 кг, раундан 336.2 мянган литр, фенизан 8.9 мянган литр, пумасупер 16.2 мянган литрийг аж ахуйн нэгжүүдэд олгож, 28.8 мянган га буюу нийт эргэлтийн талбайн дөнгөж 31.9 хувийг ариутгасан байна. Ургамал, газар тариалан судлал, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судалгаагаар тариалангийн талбайн бордох норм, бордооны хэрэгцээ шаардлагыг жилд дунджаар 41.0 мян.тн гэж тодорхойлсон байхад 2013 онд хөрсний үржил шимийг сайжруулах зорилгоор нийт 431.8 тн нийлмэл бордоог зарцуулсан нь хэрэгцээний дөнгөж 1.05 хувийг хангасан байна.
2	Химийн аргаар боловсруулах уриншийн хэмжээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:	2013 онд химийн уриншийг 135.0 мянган га талбайд хийсэн нь өмнөх оноос 13.3 мянган га-аар буурсан байна.

Эдгээр зорилтыг ханган биелүүлэхэд ҮХААЯ-ны ГТБХЗГ, СБТГ-ын холбогдох албан тушаалтнууд санаачлагагүй ажиллажээ.

II/. Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжих хугацаа 2015 онд дуусна. Гэтэл эрх зүйн орчныг шинэчлэх ажил удаашралтай, зарим ажил судалгааны болон боловсруулалтын шатандаа байгаа нь дэвшүүлсэн зорилт хугацаандаа хэрэгжихгүйд хүргэж байна. Тухайбал: "Газар тариалангийн тогтвортой хөгжил" хөтөлбөр, ойн зурвас байгуулах замаар хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах, Тариалан эрхлэх бүс бүсчилэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй шинэчлэн тогтоох, Таримал ургамлын үр сортын хуульд өөрчлөлт оруулах зэрэг зорилтуудыг дурьдаж болно. Энэ ҮХААЯ-ны ГТБХЗГ, СБТГ нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

III/. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газар тариалангийн чиглэлээр 5 зорилт дэвшүүлсэний 2 зорилт хэрэгжээгүй байна.

Дээрх 2 зорилтын хэрэгжээгүй шалтгааныг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт №4/

Д.д	Хэрэгжээгүй зорилтууд	Шалтгаан
1	Ойн зурвас байгуулах, хашаажуулах замаар тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж үржил шимийг сайжруулах	Санхүүжүүлэх эх үүсвэр нь улсын төсөвт тусгагдаагүй, мөн тус яаманд хөрсний үржил шимийг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулаагүй.
2	"Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн бүтэц, үйл ажиллагааг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн харилцан түншлэлийн корпораци болгон зохион байгуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх"	Засгийн газрын тусгай зориулалтын сангийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орсны дараа дээрх хуульд нийцүүлэн шийдвэрлэхээр Сангийн яамнаас чиглэл өгсөнтэй холбоотойгоор ажил хийгдээгүй байна.

1.2 Тариаланг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөг бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулж боловсруулсан боловч төлөвлөгөөнд тусгагдсан зарим зорилтын хэрэгжилт хангалтгүй байна

Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7¹, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1² дэх заалтуудын дагуу 2010 онд "Хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө"-г баталсан байна.

Уг төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудаас 2011-2015 онуудад 7 зорилтыг хэрэгжүүлэхээс 2 зорилт хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- Тариалан эрхлэх бүс бүсчлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй шинэчлэн тогтоох /2011-2015/ гэсэн зорилтыг хэрэгжүүлээгүй, бүс нутгийн хөрс, уур амьсгалын онцлогт тохирсон техник, технологийн шинэчлэл удаан, бүс бүрд зохицсон тариалан эрхлэх систем боловсруулаагүй байна.
- "Алслагдсан бүсүүдийн газар тариаланг сэргээн хөгжүүлэхэд шийдвэрлэх асуудлууд"-ын ТЭЗҮ-ийг тус яамнаас зөвлөх үйлчилгээгээр боловсруулан бодлого боловсруулах, төлөвлөхөд ашиглаж байгаа нь эхлэл төдий байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн талаарх зарим үзүүлэлтүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт №5/

Он	Улаанбуудай		Төмс		Хүнсний ногоо		Жимс, жимсгэнэ	
	тариалсан талбай /мян.га/	хураасан ургац /мян.тн/	тариалсан талбай /мян.га/	хураасан ургац /мян.тн/	тариалсан талбай /мян.га/	хураасан ургац /мян.тн/	тариалсан талбай /га/	хураасан ургац /тн/
2011	292.4	437.9	14.6	199.2	7.6	105.2	3887.0	881.0
2012	295.9	461.6	16.2	242.7	7.1	98.4	4506.0	1043.0
2013	275.0	369.8	15.1	190.1	8.1	101.9	5200.0	1300.0

Дээрх тоон мэдээллээс харахад стратегийн гол бүтээгдэхүүн болох улаанбуудай тариалсан талбайн хэмжээг 2012 онтой харьцуулахад 20.9 мян.га-аар,

¹ "тариалангийн салбарт төрөөс баримтлах бодлого, бүс нутгийн хөгжлийн чиг хандлагад тулгуурлан тариаланг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөг боловсруулах"

² " бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан салбарын хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг боловсруулж хэрэгжүүлэх"

хураасан ургацын хэмжээ 91.8 мян.тн-оор тус тус багассан нь тариалангийн газрын ашиглалтыг сайжруулах ажил хангалтгүй зохион байгуулсан байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2010 оны 35 дугаар захирамжаар мал аж ахуй, газар тариаланг хослон хөгжүүлэх “Халх гол” төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллах ажлын хэсэг байгуулсан байна.

Засгийн газрын 2010 оны 97 дугаар тогтоолоор мал аж ахуй, газар тариаланг хослон хөгжүүлэх, загвар аж ахуй байгуулах, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг сааруулах, үйлдвэрлэлийн өсөлтийг нэмэгдүүлж боловсруулах үйлдвэр байгуулах зорилт бүхий “Халх гол” төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэн байна.

Дээрх төлөвлөгөөнд 17 зорилт тусгаснаас 8 зорилт бүрэн, 3 зорилт дутуу, 6 зорилт хэрэгжээгүй бөгөөд төслийн хүрээнд дэвшүүлсэн гол зорилтыг хэрэгжүүлж чадаагүй, загвар аж ахуйн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах боловсон хүчин хангалтгүй, бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй иргэд ААН-ийг дэмжих талаарх зохицуулалт хийгдээгүй зэргээс үзэхэд төсөл цаашид хэрэгжих боломжгүй байна.

1.3 Тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээхтэй холбогдсон тодорхой ажил зохион байгуулаагүй, зөвхөн бордоо, ариутгалын бодис нийлүүлэх ажлыг хийжээ.

Тус яам Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9³-д заасан эрхээ хэрэгжүүлээгүй, тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээхтэй холбогдсон журмыг боловсруулж мөрдүүлээгүй байна.

Газрын нэгдмэл сангийн 2013 оны улсын нэгдсэн тайлангаас үзэхэд тариалангийн газарт учирсан хохирлын төрөл нь бүс нутгуудад ялгаатай байдаг бөгөөд газар тариалангийн бүс болох Сэлэнгэ, Хөвсгөл, Өвөрхангай аймгуудад хамгийн их буюу 5.5-9.8 мян.га талбай мэрэгч, хортон шавьжид нэрвэгдсэнээс хохирол учирсан нийт талбайн 41 хувь нь үржил шимийн бууралттай байна.

Хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулахад хийгдсэн тариалангийн хөрсний шинжилгээний дүнгээр манай орны тариалангийн талбайн 61.4 хувь нь хүчтэй, 34.9 хувь нь дунд, 3.7 хувь нь сул элдэгдэлд орсон байна.



Мастер төлөвлөгөөнд тариалангийн газрын хөрсний элэгдэл эвдрэлийг бууруулахад цогцолбор арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн боловч ҮХААЯ 2013 онд хөрсний үржил сайжруулах зорилгоор нийт 431.8 тонн нийлмэл бордоог иргэд, аж ахуй нэгжид олгосон нь газрын элэгдэл эвдрэлийг бууруулахад маш бага хувь эзлэхээр байна.

Бордооны хэрэглээ дутагдалтай, импортоор худалдан авч буй бордооны үнэ өндөр, /1 тн 987.1 мянган төгрөг/ байна. Бордооны үйлдвэр, бордоог хадгалах тусгай зориулалтын агуулах байгуулах чиглэлээр ҮХААЯ-ны зүгээс төр, хувийн

³ "Тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээхтэй холбогдсон журмыг тогтоож мөрдүүлэх"

хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээг хангалтгүй авч ажиллажээ.

- ХАА-н яаманд 2001 он хүртэл тариалангийн эдэлбэр газар хариуцсан мэргэжилтэн ажиллаж байгаад орон тоо нь цомхтгогдож 2014 оноос хариуцсан мэргэжилтэн томилогдсон байна.
- Таримал ургамлын үр, сортын сорилт хийж туршдаг 1992-1993 онд 17 үйлдвэр улсын төсвийн татаасаар ажиллаж байсан бол одоо 2-3 жижиг цех ажиллаж байна.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт "ойн зурвас байгуулах, хашаажуулах замаар тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, үржил шимийг сайжруулна"-ын хүрээнд ойн зурвас байгуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, иргэдийг бүртгэлжүүлэх ажил эхлэлийн төдий, хэрэгжилт хангалтгүй байна.

Тариалангийн талбайг хамгаалалтын ойгоор зурваслан хамгаалах нь салхины хүчийг сааруулах, цасыг жигд тогтоох, усны ууршилтыг багасгах, хөрсний экосистемийг сөрөг үр дагавараас хамгаалдаг ач холбогдолтой байхад энэ зорилтыг хангалтгүй хэрэгжүүлснээс тариалангийн талбайн хөрсний үржил шимийн чанар алдагдаж хүчтэй эвдрэлд орсон хөрс бүхий талбайн хэмжээ хэвээр байсаар байна.

Цаашид Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9-д заасны дагуу "тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх"-тэй холбогдсон журмыг боловсруулан мөрдүүлэх, хүчтэй элэгдэлд орсон газрын хэмжээг багасгах арга хэмжээг авснаар тариалангийн газрын ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ТАЛААР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд дэвшүүлсэн зорилтод хүрээгүй байна

Газар тариалангийн салбарт 2010-2014 онуудад “Чацаргана үндэсний хөтөлбөр”, “Хүнсний аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”, “Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд төмс, хүнсний ногооны зоорийн хангамж, улсын төсвийн болон гадаадын хөрөнгө оруулалтаар газар тариалан эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлээр тоног төхөөрөмж, жимсний суулгац нийлүүлсэн байдлыг авч үзлээ.

Чацаргана үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн хугацаанд улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар 10.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл дэмжлэгийг олгосноор тариалсан талбай 3.34 дахин, ургацын хэмжээ 3.38 дахин нэмэгдсэн байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд “Чацарганы суулгац зээлээр олгох”, “Жимс, жимсгэний аж ахуйд дэмжлэг үзүүлэх”, “Жимсгэний суулгац, үржүүлгийн плантаци байгуулах” төслүүд хэрэгжиж уг хөтөлбөрийн 10.1⁴ дэх заалтын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Тухайлбал:

Чацарганы суулгац зээлээр олгох төслийн хүрээнд 2010-2014 онд иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон дэмжлэгийг багцлаж үзүүлбэл: /Хүснэгт №6/

Он	Иргэн ААН-ийн тоо	Зээлээр олгосон чацаргана \сая төг\	Суулгацын тоо \мян.ш\	Тариалах талбай нормоор \га\	Тушаалын дугаар
2010	110	464.2	206.0	154.50	A/95
2011	571	1 760.2	809.4	607.05	A/98, A/271
2012	512	1 446.7	715.95	536.96	A/28, A/136
2013	237	1 432.0	693.78	520.33	A/22, A/377
2014	118	810.2	356.6	267.43	A/154, A/369
	1548	5 913.3	2781.7	2 086.28	


Төслийн хүрээнд 2010-2013 ондуудад 1548 иргэн аж ахуйн нэгжид 5.9 сая төгрөгийн өртөгтэй 2.8 сая ширхэг суулгацыг хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээлээр олгосноор улсын хэмжээнд 2.1 мянган га талбайтай жимсгэний цэцэрлэг шинээр бий болжээ.

“Жимс, жимсгэний аж ахуйд дэмжлэг үзүүлэх” төслийн сонгон шалгаруулалтаар ҮХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны А/270, А/481 дугаар тушаалуудаар 70 иргэн аж ахуйн нэгжид жилийн 2.4 хувийн хүүтэй 5 жилийн хугацаатай 2.3 тэрбум төгрөгийн зээлийг 2013 оны 7-12 дугаар саруудад олгосноор дээрх аж ахуйн нэгжүүд төслөө хэрэгжүүлж эхлэх боломжтой болсон байна.


Жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх, төрөл сортыг олшруулах, жимсгэний суулгац үржүүлэгчдийг дэмжих, дотооддоо жимсний модны суулгац

⁴ “Шилмэл сортын чацаргана, жимс, жимсгэний суулгац үржүүлэн зах зээлд нийлүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн бэлтгэсэн суулгацыг худалдан авч жимс, жимсгэнэ тариалах иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх”

бэлтгэн зах зээлд нийлүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд 7 жилийн хугацаатай 750.0 сая төгрөгийн хүүгүй зээлийг төслийн сонгон шалгаруулалтаар 8 байгууллагад 2013 оны 5-6 дугаар саруудад бүрэн олгожээ. /Графикаар харуулбал/



Дээрх байгууллагууд 35,24 га эх цэцэрлэг байгуулж давхардсан тоогоор 12 төрлийн 164 сортын жимсгэний 36948 ширхэг суулгацыг тариалсан байна.




Төслүүдийн хэрэгжилтийг ХХААЯ-ны ГТБХЗГ, ТЭДС-гаас томилогдсон ажлын хэсэг 2014 онд шалгаж эдгээр төслүүдэд хамрагдан хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл авсан 5 аймаг болон нийслэлийн 160 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллага дээр очиж ажилласан ба биелэлт 82.6 хувьтай гэж дүгнэсэн байна.

Жимс жимсгэний аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх төслөөс санхүүжигч 67 иргэн, ААН эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2014 оны 7 дугаар сарын 31-нээс

12 дугаар сарын 1-ний хооронд нийт 51.4 сая төгрөгийн зээлийн хүү төлөхөөс 20 иргэн ААН 12.5 сая төгрөгийн хүүг төлж хүүгийн төлбөр гүйцэтгэл мөнгөн дүнгээрээ 24.3 хувьтай 47 иргэн ААН 38.9 сая төгрөгийн хүүгийн төлбөрөө хийгээгүй буюу зээлдэгчдийн 70.1 хувь нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

Аудитын явцад “Чацаргана үндэсний хөтөлбөр”-ийн 6, 9 дүгээр бүлгүүдийн холбогдох заалтуудын дагуу 2013 оны байдлаар 4 үзүүлэлтээр суурь болон зорилтот түвшин хүрсэн үр дүнгийн үнэлгээг радар график ашиглан хийхэд дараах байдалтай байна.



Төслийн гүйцэтгэлээр 5200 га талбайд чацарганы суулгац тариалсан нь зорилтот түвшин 12500 га-тай харьцуулбал 42 хувиар хэрэгжсэн байна.

Чацаргана үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилт үр дүнгийн гүйцэтгэл 2009 оны суурь түвшинтэй харьцуулахад сайн байгаа хэдий ч зорилтот түвшинтэй харьцуулахад хангалттай бус байгаа нь хэт өндөр төлөвлөсөнтэй холбоотой.

Төмс, хүнсний ногооны зоорь агуулахын хангамжийг сайжруулах төслөөр хувийн хэвшлийн ААН-д улсын төсвөөс дэмжлэг олгохдоо тухайн хуулийн этгээдийн дүрмийн санд өөрчлөлт оруулаагүй байна

Засгийн газраас 2006-2010 оны хооронд хэрэгжүүлсэн “Атрын 3 дугаар аян”-ны дараагийн шатанд хийгдэх ажлуудыг “Хүнсний аюулгүй байдлын хөтөлбөр”-ийн төсөл арга хэмжээнд тусгаж хэрэгжүүлсэн байна.

Монгол улсын засгийн газраас 2010-2012 онд зоорь агуулахын хангамжийг сайжруулах зорилгоор нийт төсөвт өртөгийн 70 хувийг өөрийн хөрөнгөөр

санхүүжүүлсэн 48 иргэн, аж ахуйн нэгжид улсын төсвөөс 6.3 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

2009 оны байдлаар улсын хэмжээнд зоорийн хадгалах хүчин чадал 110.0 мянган тонн байсан бол уг төсөл арга хэмжээний хүрээнд 40.3 мян.тн-оор нэмэгдсэн ба зоорийн нийт багтаамжийг хураан авсан ургацтай харьцуулахад хадгалах хүчин чадлын хангамж 2014 онд 71.5 хувьтай байна.



Зоорь агуулахын хангамжийг сайжруулахад улсын төсвөөс олгосон 6.3 тэрбум төгрөгийн хөрөнгө төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдийн санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.3⁵ дахь заалтад нийцэхгүй байна.

Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын жагсаалт. Хавсралт хүснэгт №1

2.2 Хөнгөлөлттэй олгосон техник, тоног төхөөрөмжийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна

Газар тариалангийн салбарт 2011-2014 оны хооронд улсын төсвөөс 18.6 тэрбум төгрөг, гадаадын хөнгөлөлттэй зээлээр 40.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэнийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №7/

№	Техник, тоног төхөөрөмж	2011		2012		2013	
		Т/ш	Сая.төг	Т/ш	Сая.төг	Т/ш	Сая.төг
1	Зүтгэх хүчний трактор, иж бүрдэл /том оврын/	2	1832.4	9	3496.2	-	
2	Үр тарианы комбайн	19	2936	23	3498.3	-	
3	Чиргүүл дүүжин машин	84	1272.5	75	500	577	1656.5
4	Үтрэмийн тоног төхөөрөмж	34	1081.2	-	-	-	
5	Төмс, хүнсний ногооны иж бүрдэл	292	2546	-	-	-	
6	Нийт	431	9668.1	107	7494.5	577	1656.5

Эдгээр төхөөрөмжийг худалдан авсан зээлийн эргэн төлөлт хангалтгүй үүнд тавих дотоодын хяналт сул байна. Зээлийн эргэн төлөлтийн байдлыг хүснэгтээр харуулбал:

⁵ Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдтэй хамтарч хөрөнгө оруулсан бол төсвөөс санхүүжүүлсэн хувь хөрөнгийн хэмжээгээр төрийн болон орон нутгийн өмчид хамааруулна.

		/тэрбум төгрөг/			Хүснэгт №8
№	Он	Графикт хугацаа /он/	Эргэн төлөгдөх	Төлсөн	Хувь
1	2011	2011-2014	2.0	1.6	79
2	2012	2012-2014	1.9	1.3	70
3	2013	2013-2014	1.3	0.846	65
нийт			5.2	3.7	71.3

Дээрх хүснэгтээс үзэхэд сүүлийн 3 жилд 1.5 тэрбум төгрөг төлөгдөөгүй бөгөөд ХХААЯ, ТЭДСан өр авлагыг барагдуулах талаар тодорхой ажлыг зохион байгуулаагүй нь Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.2⁶, ТЭДС-г бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журмын 8 дугаар зүйлийн 1⁷, мөн журмын 11 дүгээр зүйлийн 3⁸-т заасан заалтыг биелүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Хөдөө аж ахуйн салбарт гадаадын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн борлуулалт удаашралтай байна

“БНХАУ-ын Засгийн газраас олгосон 500.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл”-ийн хэлэлцээрийн хүрээнд нийт 40.0 сая ам долларын хөрөнгө оруулалт хийгдэхээс одоогийн байдлаар нийлүүлсэн 27.9 сая төгрөгийн өртөг бүхий бага оврын тракторын борлуулалтыг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт №8/

							/тоо ширхэг/	Хүснэгт №9
Нэр төрөл	Хэмжих нэгж	Хүлээн авсан	2012	2013	2014	Нийт	2014.11.04 байдлаар үлдэгдэл	Үнийн дүнгээр сая.төг
FT-250	Иж бүр	5250	550	352	794	1696	3554	17770
FT-200	Иж бүр	3150	2647	490	13	3150	0	0
Нийт		8400	3197	842	807	4846	3554	17770
Үнийн дүнгээр сая.төг		42000	15985	4210	4035	24230	17770	17770

Хадлангийн зориулалттай трактор нь бүрэн зарагдсан ба газар тариалангийн зориулалттай тракторын борлуулалт 33 хувьтай байна. Тариалангийн зориулалттай трактор нь сүүлийн 2 жилд дундажаар 824 ширхэг зарагдсанаар тооцвол 4-5 жилийн дараа бүрэн борлуулж дуусахаар байна.

Тракторыг дагалдах хэрэгслийн хамт хадгалж хамгаалах ажлын хүрээнд 4 га газрыг ашиглахаар 2013 оны 6 дугаар сарын 18-ны өдөр ТЭДС “Мадимос групп” ХХК-тай гэрээ байгуулж одоог хүртэл задгай талбайд хадгалж сар бүр 4 га газрыг ашигласны төлбөрт 6.0 сая төгрөгийг хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийн орлогоос төлж байна.

⁶ тариалангийн салбарт хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг боловсруулж, түүний хэрэгжилтэд хяналт тавих, нэгдсэн удирдлагаар хангах;

⁷ сангийн хөрөнгөөс эргэн төлөх нөхцөлөөр олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт тавьж, зээлийг хугацаанд нь төлүүлэх ажлыг зохион байгуулах

⁸ сантай холбогдон үүссэн өр, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах;

2014 оны 11 дүгээр сарын байдлаар дээрх талбайд 2225 трактор, дагалдах хэрэгслийн хамт, ТЭДС-ийн хашаанд үлдэгдэл 1329 ширхэг нь тус тус хадгалагдаж байгаа ба хадгалалтын зардалд 2014 оны 11 дүгээр сарын байдлаар 102.0 сая төгрөг зарцуулсан байна.

Үлдэгдэл тракторын борлуулалтыг сайжруулах зорилгоор Фотон-250 маркын тракторт зориулагдсан өнөөгийн зах зээлд хэрэгцээтэй байгаа хадлангийн хадуур тармуур, суулгацын нүх ухагч, өөрөө буулгагч болон энгийн чиргүүлийг зээлийн эргэн төлөлтийн орлогоос БНХАУ-аас 1.1 тэрбум төгрөгөөр оруулж ирэн иж бүрдэл болгон борлуулж байгаа боловч төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.

Хадгалалтын байдлыг зургаар үзүүлбэл:



Дээрхээс харахад бага оврын тракторын борлуулалт 57.7 хувьтай, зээлийн эргэн төлөлт 19 хувьтай байна. Нийт тракторын 42.3 хувь буюу дунджаар 17.7 тэрбум төгрөгийн өртөгтэй техник задгай талбайд хадгалж байгаа ба техник, тоног төхөөрөмжийн элэгдэл хоргодол ихтэй, нар салхинд гандсан, суудлын бүрээс хөлдөж хагарсан, резинэн эдлэлүүд нь хуучирч муудсан байдалтай байна.

Өмнөх үе шатны 27.9 сая ам.долларын зээлийн хөрөнгийн зарцуулалт үр ашиггүй, техник, тоног төхөөрөмжийн борлуулалт, эргэн төлөлт хангалтгүй байхад Засгийн газрын 2013 оны 127 дугаар тогтоолын дагуу БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 2014 онд 12.07 сая ам.долларын хөрөнгөөр 125 морины хүчтэй трактор чиргүүлийн хамт 90 ширхэг, 165 морины хүчтэй трактор 42 ширхэг, үр тарианы комбайн 48 ширхэг, эрдэнэшишийн комбайн, үрлэгч тус бүр 10 ширхэгийг

худалдан авахаар тогтож, ЭЗХЯ, тус улсын ЭКСИМ банктэй зээлийн тусгайлсан хэлэлцээрийг байгуулсан нь улсын өр нэмэгдүүлэх эрсдлийг бий болгож байна.

2.3: Тариалангийн салбарт улсын төсвийн болон гадаадын зээл тусламжаар техник төхөөрөмж нийлүүсэнээр хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулах нөхцлийг бүрдүүлжээ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 93.13⁹ дахь заалтын дагуу импортоор оруулж буй тоног төхөөрөмжийн гааль НӨАТ-ыг чөлөөлөх, аймгуудад тоног төхөөрөмжийн танилцуулга, үзэсгэлэн зохион байгуулах, төсөл хөтөлбөрийн шугамаар 2010-2013 онуудад иргэн, аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээлээр төмс хүнсний ногоо, үр тарианы тариалалт, үрслэгээ хөрс боловсруулалтын ажлыг гүйцэтгэх зориулалт бүхий тоног төхөөрөмжүүдийг нийлүүлснээр хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, нэгжээс авах ургацын хэмжээг өсгөхөд зохих үр дүнгээ өгчээ.

Өрхийн болон жижиг аж ахуйдад зориулсан бага оврын тоног төхөөрөмжүүд нийлүүлснээр бий болсон дэвшилүүдийг дурьдвал: /Гар ажиллагаатай харьцуулснаар/
/Хүснэгт №10/


Д/д	Бага оврын тракторт нийцсэн төхөөрөмжүүд	Нийлүүлэгдсэн тоо /ш/	Хүчин чадал /га өдөр/	Бүтээмжийн өсөлт /дахин/	Нэвтэрсэн дэвшилтэт технологи	
1	Хүнсний ногооны үрлүүр	110	2	40	Гар ажиллагааг механикжуулсан, бага оврын тракторт нийцсэн.	
2	Үрслэгээ суулгагч	38	3	60	Байцаа сонгины үрслэгээг богино хугацаанд талбайд суулгах боломж бүрдсэн.	
3	Хөрс боловсруулах мотоблок	180	1	64	Хөрсний чийгийг хамгаалах, хог ургамал ургахгүй байх нөхцлийг бүрдүүлэх, гар ажиллагааг механикжуулан хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлсэн дэвшилтэт технологид суурилсан.	
4	Роторт сийрүүлүүр	110	1	2,5 ¹⁰	Нэг явалтаар сийрүүлэх, булдах, борнойдох, тэгшлэх зэрэг 3-4 үйлдлийг гүйцэтгэх боломжтой.	

Төсөл хөтөлбөрүүдийн үр дүнд 2010-2014 онд иргэд ААН-үүд үр тарианы комбайн 87 ш, трактор 156, сийрүүлүүр 115, жатка 34 ш, үрлүүр 155 ширхэгийг хувийн хөрөнгө оруулалтаар худалдан авч техникийн шинэчлэл хийжээ.

Дээрх дэвшилтэт тоног төхөөрөмжийг ашигласнаар газар тариалангийн ажилд хугацааны өөрчлөлт орсныг графикаар үзүүлбэл:

⁹ "Хөрс боловсруулах, ургац хураах, ургамал хамгаалах орчин үеийн техник, тоног төхөөрөмжийн хангамжийг 50 хувь хүртэл нэмэгдүүлнэ."

¹⁰ Сийрүүлэлт, булдах, борнойдох, тэгшлэх үйлдлийг тус тусд нь хийсэнтэй харьцуулсан бүтээмж



Үр тарианы үйлдвэрлэлд техник шинэчлэл хийж дэвшилтэт техник технологи нэвтрүүлснээр тариалалт, хөрс боловсруулалт, ургац хураалтын ажлыг гүйцэтгэх технологи хугацааны өөрчлөлтийг 2010 онтой харьцуулан авч үзвэл тариалсан талбай 16,72 хувиар өсч, тариалалт 7 хоног, уринш боловсруулалт 14 хоног, ургац хураалт 4 хоногоор тус тус буурчээ.

Тариалан эрхлэлтийг дэмжих санд худалдан авах үрийн болон хүнсний улаанбуудайн үнийг 550.0 төгрөгөөр тогтоосон байна

ТЭДС-г бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих, тайлагнах журмын 20¹¹ дахь заалт-ын дагуу 2010-2014 онуудад уг санд худалдан авах, борлуулах үрийн болон хүнсний улаан буудайн үнийг тогтоож иржээ.

Энэ журмын дагуу ТЭДС, ГТБХЗГ буудайн өртгийн судалгааг хийж Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн 2014 онд 460.0 төгрөгөөр нэг кг хүнсний улаанбуудайг худалдан авахаар ҮХАА-н сайдын 2014 оны А/53 дугаар тушаалыг гаргуулжээ.

Гэвч долларын ханш, хэрэглээний үнийн өсөлттэй холбоотойгоор мэргэжлийн холбоод, тариаланчдын зүгээс стартегийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх, гадаад зах зээлийн өрсөлдөөнөөс үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах талаар төр засгийн удирдлагуудад тавьсан саналд үндэслэн гурил үйлдвэрлэгчид, тариаланчид, ҮХААЯ-ны төлөөлөл гурван талт уулзалт хийж ТЭДС-д худалдан авах үрийн болон хүнсний улаан буудайн үнийг ҮХАА-н сайдын 2014 оны А/107 дугаар тушаалаар элеватор нөхцлөөр 550.0 төгрөг болгож шинэчлэн тогтоож хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

¹¹ “Санд худалдан авах, борлуулах үрийн болон таваарын буудай, таримал ургамлын үрийн хэмжээ, үнийн доод хэмжээг зах зээлийн тухайн жилийн ханшийг харгалзан Хүнс, хөдөө аж ахуйн сайд тогтооно.”

БҮЛЭГ 3. ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН ЭЗЭМШИЛТ АШИГЛАЛТЫН БАЙДАЛ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Газар тариалангийн газрыг өмчлүүлэхтэй холбоотой ажлын явц эхлэл төдий байна

ҮХААЯ тариалангийн газрыг иргэн, ААН-д хуулийн дагуу эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх талаар судалгаа, шинжилгээ хийгээгүй, тодорхой тоо баримт байхгүй байгаа бөгөөд уг асуудлаар шаардлагатай мэдээллийг Газрын харилцаа, геодези зураг зүйн газраас жил бүр гаргадаг газрын нэгдмэл сангийн улсын нэгдсэн тайланд тусгагдсан мэдээг авч ашигладаг байна.

ҮХАА-н сайдын 2014 оны А/115 дугаар тушаалаар ҮХААЯ, ГХГЗЗГ-тай хамтран ажиллах санамж бичиг гаргаж тариалангийн газрын сансрын зургийн өгөгдлийн сан байгуулахад шаардагдах 765.0 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэн Төрийн нарийн бичгийн даргын А/415 дугаар тушаалаар уг ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулан сонгон шалгаруулалтыг эхлүүлсэн хэдий ч ажил зогсож эх үүсвэр татагдсан байна.

2013 оны Улсын газрын нэгдмэл сангийн ангиллын өөрчлөлтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт №11/

Газрын нэгдмэл сангийн ангилал	2012	2013	зөрүү /мян.га/
Тариалангийн газар	1031.1	986.8	-44.3
Атаршсан газар	292	304.9	12.9

Тариалангийн газрын хэмжээ өмнөх оноос 44.3 мян.га-аар багассан, атаршсан газрын хэмжээ 12.9 мян.га-аар ихэссэн байхад ҮХААЯ 2013 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайландаа атаршсан газар ихэссэн, тариалалт хийх талбай буурсан талаар мэдээлээгүй бөгөөд эргэлтийн талбайн хэмжээг бодитой, үнэн зөвөөр Засгийн газарт тайлагнаагүй байна.

Цаашид тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулах, тариалангийн зориулалтаар шинээр ашиглаж болох газрын судалгаа хийх, нөөцийг тогтоох, цаашид ашиглах тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

3.2 Тариалангийн газрыг нөхөн сэргээх ажил хийгдээгүй байна

Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4¹², 5.1.9¹³ дэх заалтуудын дагуу тариалангийн газрын зориулалтыг өөрчлөх, сайжруулах, нөхөн сэргээлт хийх үйл ажиллагаа дараах байдалтай байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгөөр газар тариалангийн зориулалттай газрын үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээлт хийх ажлууд 2013-2014 онуудад хийгдээгүй бөгөөд иргэн, аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр тодорхой түвшинд ажил гүйцэтгэдэг хэдий ч энэ талаар яамны зүгээс гаргасан бүртгэл судалгаа байхгүй, төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлсний үр дүнд иргэн, аж ахуйн нэгжүүд хөрсийг салхины элэгдлээс хамгаалах, чийг хуримтлуулах, үржил шимийг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлсэн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж буй хэдий ч хичнээн га

¹² “Энэ хуулийн 7.1.3-т заасан тариалангийн газрын зориулалтыг өөрчлөх, атар газрыг тариалангийн газар болгох талаарх аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газарт оруулах”

¹³ “Тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээхтэй холбогдсон журмыг тогтоож мөрдүүлэх”

талбайд энэхүү технологийг ашигласнаар хөрсний чанар байдал сайжирсан эсэх талаар судалгаа хийгдээгүй байна.

“Тариалангийн тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.6¹⁴, 16.7¹⁵-д заасны дагуу тариалангийн зориулалттай газар эзэмшиж буй иргэн, ААН-үүдийн агро химийн шинжилгээ хийлгэсэн талаарх бүртгэл байхгүй, шинжилгээ хийх аргачлалыг боловсруулж батлаагүйгээс энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй байна.

ҮХААЯ тариалангийн газрын үржил шимийг дээшлүүлэх, нөхөн сэргээхтэй холбоотой бодлогын баримт бичиг гаргах, зохион байгуулалтын арга хэмжээ авах, шаардлагатай хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

¹⁴ “Агрохимийн шинжилгээг 5 жил тутамд нэг удаа заавал хийлгэх бөгөөд өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хүсэлт, холбогдох төрийн байгууллагын шаардлагаар агрохимийн шинжилгээг хугацаа харгалзахгүйгээр хийлгэж болно”

¹⁵ “Тариалангийн газрыг иргэн, хуулийн этгээдэд өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулахаар анх удаа олгох, нөхөн олговортойгоор эргүүлэн авах, хураан авах, тариалангийн газрын зориулалтыг өөрчлөхөд агрохимийн шинжилгээг заавал хийнэ”

БҮЛЭГ 4. ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЖУРМЫН БИЕЛЭЛТЭД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ

4.1 Тариалангийн тухай хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэнд тавих дотоод хяналт хангалтгүй байна

ҮХААЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар байгууллагын үйл ажиллагаа, хөтөлбөрийн үр ашигтай ба үр нөлөөтэй байдал, хөрөнгийн хамгаалалт, хууль тогтоомж, дүрэм журмын мөрдөлтөд хяналт хийж, үйл ажиллагаанд бодит үнэлгээ өгөх чиг үүрийг хүлээсэн байна.

ХШҮДАГ нь МУ-ын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндсэний хөгжлийн цогц бодлого, ЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийхдээ ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам"-ыг удирдлага болгон ажилласан байна.

Тус газар 2013 онд зарим аймгуудын ХААЖДҮГ, ТҮДТ, "Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөр, "Чацаргана" хөтөлбөр, "Халх гол" төслийн хэрэгжилтэд дотоод аудит хийж илрүүлсэн зөрчлүүдийн хүрээнд зөвлөмж гарган холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн боловч өгөгдсөн зарим зөвлөмжийн биелүүлээгүй, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцсон эсэх талаар тодорхойгүй байна.

"Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам"-ын 5.6¹⁶-д заасны дагуу 2012 онд хэрэгжиж дууссан "Ногоон хувьсгал" хөтөлбөрийн үр дүнд үнэлгээ хийж хүнсний ногооны ургац нэмэгдсэн боловч хүнсний ногооны хангамжаа 100 хувь хангаж чадаагүй тул тус хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан харин Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын нэгдүгээр үе шатанд тавьсан зорилтот түвшинд хүрсэн эсэхэд үнэлгээ өгөөгүй байна.

Тус газрын хяналт шинжилгээ үнэлгээний тайланд зарим зөрүүтэй буруу мэдээлэл байна. Тухайлбал:

- МУ-ын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын зорилтын хэрэгжилтийн тайланд ашиглаж байгаа тариалангийн талбайн хэмжээг 3 өөр дүнгээр тайлагнасан байна. Тухайлбал: "2012 онд ашиглаж байгаа тариалангийн талбайн хэмжээ 690.0 мян.га, 2013 онд нэмж атар газар ашиглаагүй", "2013 онд ашиглаж байгаа тариалангийн талбайн хэмжээ 23.0 мянган га-гаар нэмэгдэж 717.0 мянган га-д хүрсэн", "ашиглаж байгаа тариалангийн талбайн хэмжээ 694.0 мянган га" гэх мэт
- Мөн МУЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэрэгжилтэд: "Дотоодын үржүүлэгчдээс 770.0 мянган ширхэг чацарганы суулгацыг худалдан авч 18 аймгийн 208 иргэн, аан-д олгосон", "чацарганы суулгацыг 255 иргэн, аан-д олгосон" гэж тайлагнасныг хариуцсан мэргэжилтнээс тодруулахад "ҮХААЯ-ны сайдын 2013 оны 05 дугаар сарын 01-ний А/122 тушаалын хавсралтаар 182, 2013 оны 10 дугаар 08-ны А/377 тушаалын хавсралтаар 58 иргэн, аан-д нийт 240 иргэн, аан-д олгосон байна.

Хяналт шинжилгээ үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан журмын 6.3-д заасан "хяналт шинжилгээ, үнэлгээ нь тоо баримт, судалгаа, мэдээлэлд үндэслэсэн, тухайн бодлого, хөтөлбөр, төслийн үр дүн,

¹⁶ "Үр дүнд суурилсан нэгтгэн дүгнэх үнэлгээ" гэдэг нь үйл ажиллагааны жилийн тайлан болон хэрэгжиж дууссан тодорхой бодлого, хөтөлбөр төсөл нь зорилтот түвшинд хүрсэн эсэхэд эцсийн байдлаар үнэлж үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлон цаашид тухайн чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлэх эсхүл зогсоох чиглэлээр дүгнэлт, гаргах үйл ажиллагааг юм.

үр ашиг, үр нөлөөг тодорхойлсон, **хэмжигдэхүйц, нотлогдохуйц байх**" гэсэн зарчмыг баримтлаагүй тайланд тусгагдсан тоон мэдээллүүд хоорондоо зөрүүтэй, үнэн зөв, бодит мэдээллэгдээгүй, зарим бодлогын үр дүн, үр ашиг бүрэн тодорхойлогдоогүй байна.

Тариалангийн тухай хуульд зааснаар ҮХААЯ нь 5 дугаар зүйлийн 5.1.3¹⁷, 5.1.9¹⁸-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлээгүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №4-д/

Шалтгааныг холбогдох мэргэжилтнүүдээс тодруулахад "Тариалангийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д заасны дагуу жил бүрийн 4 дүгээр улирал буюу 11 дүгээр сард багтаан улсын хэмжээний нийт тариалсан, уриншилсан газрын хэмжээ болон хураасан ургацын тайланг Засгийн газарт танилцуулдаг, харин өнжөөсөн, атаршсан газрын талаарх тайланг эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын харилцаа геодези зураг зүйн газраас Засгийн газарт танилцуулдаг." гэсэн тайлбарыг өгсөн болно.

¹⁷ улсын хэмжээнд нийт тариалсан, уриншилсан, өнжөөсөн болон атаршсан газрын хэмжээ, хураасан ургацын тайланг Засгийн газарт танилцуулах;"

¹⁸ тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээхтэй холбогдсон журмыг тогтоож мөрдүүлэх;"

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Газар тариалангийн салбарын бодлогын баримт бичгийг боловсруулахдаа үндэслэл бүхий судалгаа шинжилгээ хийдэггүй, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тусгаж өгдөггүйгээс дэвшүүлсэн зорилтот түвшинд хүрч чадаагүй байна.
2. Тариалангийн газрын шинэтгэлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх замаар газрыг зах зээлийн эргэлтэд оруулах, талбайн ашиглалт, үржил шимийг сайжруулах, шинээр ашиглаж болох газрын судалгаа хийх, нөөцийг тогтоох, тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулаагүй байна.
3. Төмс хүнсний ногооны зоорь агуулахын хангамжийг дээшлүүлэх зорилгоор улсын төсвөөс олгогдсон 6.3 тэрбум төгрөгийн хөрөнгө хувийн хэвшлийн хөрөнгөд бүртгэгдсэн байна.
4. Газар тариалангийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд ААН, иргэдэд хөнгөлөлттэй нөхцлөөр олгож байгаа зээлийн эргэн төлөлт хангалтгүй, ҮХААЯ, ТЭДС нь хууль, журамд заасан үүргээ биелүүлээгүй байна.
5. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр худалдан авсан техник, тоног төхөөрөмжийн борлуулалт, хангалтгүй, хадгалалт хамгаалалттай холбоотой асуудлыг зохистой шийдээгүй байхад 2015 онд дахин зээлийн эх үүсвэрийг ашиглаж худалдан авалт хийхээр гэрээ байгуулсан нь улсын өрийг нэмэгдүүлэх эрсдэл бий болгож байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдагсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдад:

1. Газар тариалангийн чиглэлээр гаргасан хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах.
2. Тариалангийн зориулалттай газрын судалгаа, мэдээллийн санг бий болгож, газрыг зах зээлийн эргэлтэд оруулж, ашиглалтыг сайжруулах, тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх арга хэмжээг авч ажиллах.
3. Тариалангийн салбарын өртгийн судалгаанд үндэслэн тооцоо хийж үрийн болон хүнсний улаанбуудай худалдан авах борлуулах үнийг тогтоох.
4. Тариалангийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, үргүй зардал гаргахгүй байх.
5. Зээлийн хөрөнгөөр авсан тоног төхөөрөмжийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, шинээр тоног төхөөрөмж худалдан авахдаа зах зээлийн багтаамжийн бодит судалгаанд тулгуурлах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2015 оны 4 сарын 24 өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Тариалангийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн, төрөөс газар тариалангийн салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаа үр дүнд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Хүнс, Хөдөө аж ахуйн яаманд хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2015 оны 12 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүнс, Хөдөө аж ахуйн сайдад зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга (Б.Алтанзул)-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Хавсралт хүснэгт №1

УЛСЫН ТӨСВӨӨС ЗООРИЙН ДЭМЖЛЭГ АВСАН ИРГЭН АЖ АХУЙ НЭГЖИЙН СУДАЛГАА

Аймаг хот	Компанийн нэр	Зоорины багтаамж /тн/	Нийт	өөрийн хөрөнгөөр	хөрөнгө оруулалтын дэмжлэг	Байршил
Улаанбаатар	"Эрдэнэ-Энхтрейд" ХХК	2000	1400	980.00	420.00	УБ СХД 20-р хороо
	"эм-Эс-Эс-Ди" ХХК	1000	192.5	134.70	57.80	Гэрээ гаргаж өгөөгүй
	"Баг жакс" ХХК	1000	260.8	182.80	78.00	СХД 21-р хороо Эмээлт
	"Биг харвест" ХХК	850	367.1	257.10	110.00	УБ СХД 20-р хороо
	Их Булгийн тохой" ХХК	1000	863.5	629.50	234.00	СХД
	"Сүмбэр групп"ХХК	1000	324.2	216.90	107.30	СХД 8-р хороо
	Д.Сүхбаатар	100	48.7	34.70	14.00	УБ СХД 8-р хороо
	Орхон шим хоршоо	200	120	84.00	36.00	УБ СХД 22-р хороо
	"Грийн сити" ХХК	650	264	214.00	50.00	Гэрээ гаргаж өгөөгүй
	Ньюкроп" ХХК	1500	806	624.00	182.00	Гэрээ гаргаж өгөөгүй
	О.Наранчимэг	30	32.1	22.50	9.60	СХД 21-р хороо
	Л.Эрдэнэ	150	39.9	27.90	12.00	Гэрээ гаргаж өгөөгүй
	МПУХ-ны сувилалын газар	50	120.5	84.50	36.00	Гэрээ гаргаж өгөөгүй
	"Актив хийц"ХХК	2250	1327.2	929.20	398.00	БЗД 6-р хороо
	"М-Ти-Эс" ХХК	4500	4810	3,641.50	1,168.50	БГД 20-р хороо
	"Шижи-Импекс" ХХК	80	500	350.00	150.00	БГД 20-р хороо
	"Минимакс" ХХК	350	350	283.00	67.00	Налайх
	Мандтрейд" ХХК	500	282.7	198.70	84.00	Налайх 1-р хороо энгэр шанд
	"Сөөсгөр" ХХК	2000	1000	700.00	300.00	Гэрээ гаргаж өгөөгүй
	"Мөнх амгаланбат" ХХК	800	468	328.00	140.00	Гэрээ гаргаж өгөөгүй
	"Илч хангай" ХХК	1000	765	535.00	230.00	Гэрээ гаргаж өгөөгүй
	"Актив хүнс"ХХК	1000	1190	836.00	354.00	СХД 21-р хороо
	Эко-Монголиа ХХК					Гэрээ гаргаж өгөөгүй
	"Систем капитал" ХХК	300	172.6	121.60	51.00	Налайх4-р хороо
Төв	"Ай эн эйч ХХК	500	215.3	155.30	60.00	СБД 15-р хороо
	Баянчандмань "Р.Батаа"	50		(15.00)	15.00	Чандмань баг
	Баянчандмань Р.Цоггэрэл	120	134.5	104.50	30.00	Баянчандмань сум
	"Атаасү"ХХК	400	470.3	350.30	120.00	СХД 21-р хороо Жаргалантын ам
	"Агро-алвфа" ХХК	2000	1064.5	764.50	300.00	УБ СХД
	"Органик буудай" ХХК	200	127.7	92.70	35.00	Баянцогт сум
	Борнуур "Сорт сорилтын салбар	100	21.9	15.30	6.60	Гэрээ гаргаж өгөөгүй

	Аргалант "Жикс" ХХК	300	362.9	282.90	80.00	Төв Аргалант сум
	Топ секвойя" ХХК	1000	635.5	445.50	190.00	Төв Баянчандмань сум
	Р.Батаа	50	63.5	48.50	15.00	Төв Баянчандмань сум
	Жаргалант Ц.Эрхэмбаяр	200	100.1	77.10	23.00	Гэрээ гаргаж өгөөгүй
Архангай	Тариат "Р.Түмэнбаяр	100	75	50.00	25.00	Тариат сум
	"Од кр"хоршоо	600	254.1	174.10	80.00	Эрдэнэбулган сум
	Баянгол "Ц.Зундуй	1000	350.1	245.10	105.00	Баянгол сум
	Хушаат "Өгөөж бумбат" ХХК	1200	534.8	364.40	170.40	Хашаат сум Бумбатын тохой
	Х.Батцэнгэл"Ерөө"	120	116.2	86.20	30.00	Гэрээ гаргаж өгөөгүй
	Зүүнбүрэн "миний ээж" ХХК	100	137.8	98.80	39.00	Зүүнбүрэн сум 2-р баг
	Р.Түмэнбаяр	100	85.7	60.70	25.00	Архангай тариат
	Сант "Эй си ди" ХХК	1000	804.2	674.20	130.00	Сант сум
Дархан	Орхонтуул "Их номт" ХХК	500	105.3	75.30	30.00	Сэлэнгэ орхонтуул
	Н.Батбаатар	200	64.8	45.80	19.00	Гэрээ гаргаж өгөөгүй
	"Хос шарга" ХХК	250	180.3	136.30	44.00	Дархан сум 15-р баг
	"Хатан сэлэнгэ-Орхон" ХХК	500	346.1	246.10	100.00	Дархан сум 9-р баг
Орхон	"манлай ургац" ХХК	1500	460	346.00	114.00	Гэрээ гаргаж өгөөгүй
Хөвсгөл	Баянөндөр Т.Цэрэнтогтох	50	10	7.00	3.00	Гэрээ гаргаж өгөөгүй
Хэнтий	Галт сум"Өөдлөх галт" хоршоо	50	89.9	62.90	27.00	Гэрээ гаргаж өгөөгүй
	Ж.Алтантөгс	50	30.2	21.20	9.00	Хэрлэн сум 5-р баг
	"Алтан хурх" ХХК	500	473.4	331.40	142.00	Гэрээ гаргаж өгөөгүй
Өвөрхангай	Занданшоориса ХХК	120	128	89.60	38.40	Гэрээ гаргаж өгөөгүй
Дорнод	Халх голын хишиг ХХК	300	110	77.00	33.00	Гэрээ гаргаж өгөөгүй
	Модуньшаньюы ЗГБХН	200	127.7	89.70	38.00	Хэрлэн сум